

ЗӨВШӨӨРСӨН.
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц.ЭРДЭМБИЛЭГ

Ц. Эрдэмбилэг



БАТЛАВ.
ЭРХҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭХ БАРИХ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д.МӨНХЦЭЦЭГ



ЭХ БАРИГЧИЙН “ЖИРЭМСЛЭЛТЭД БЭЛТГЭХЭД ЗӨВЛӨГЧ”
МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
(PRECONCEPTION MIDWIFE COUNSELLOR)

МЭРГЭШЛИЙН ИНДЕКС: S(s)09130028
СУРГАЛТЫН ХУГАЦАА: 3 сар

УЛААНБААТАР
2022

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН БАГ:

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төлөөлөл:

Б.Туул	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч;
Я.Оюунбилэг	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
П.Цэцэгмаа	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Сувилахуйн ухааны доктор, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
Х.Цэцэгсүрэн	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Анагаахын шинжлэх ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
Л.Туяацацрал	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаахын шинжлэх ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч;
С.Сэржням	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр;

Сургалт эрхлэх байгууллагын төлөөлөл:

Ч.Бурмаа	Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
С.Даваасүрэн	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, Сувилахуйн ухааны магистр, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн тэргүүн;
Д.Уламбаяр	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны арга зүйч, Зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
Д.Насантогтох	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ахлах эх баригч, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
М.Мөнхөө	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн албаны арга зүйч, тэргүүлэх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
С.Түмэнжаргал	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн арга зүйч, тэргүүлэх зэргийн эх баригч;

Зөвлөх багийн төлөөлөл:

Икэмото Мэгүми Сувилахуйн ухааны доктор, ЖАЙКА Олон улсын байгууллагын “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн эх баригчийн сургалт хариуцсан мэргэжилтэн,

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Б.Туяа Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн;
Д.Дондогмаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр;
Д.Энхтуяа Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэргэжил Дээшлүүлэх Институтийн Сувилахуйн төгсөлтийн дараах сургалт хариуцсан ахлах арга зүйч, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга;

ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАСАН:

П.Эрхэмбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дэд дарга, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч;

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Хүн төвтэй эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ гэдэг нь хүмүүс амьдралынхаа туршид өөрийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх үйлчилгээг эрүүл мэндийн салбарын болон салбарын бус байгууллагаар дамжуулан иж бүрнээр тодорхой шатлалтайгаар хүртэх боломжоор хангагдсан байхыг хэлнэ. (ДЭМБ, 2016).

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эхийн эндэгдлийн харьцааг 2020 онд 25 болгож бууруулахаар зорьсон байна.

Манай улсад эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөнд 1990 оны түвшинтэй харьцуулахад 176-оор буурч, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрээд байна.

Жирэмсэн үеийн хяналт нь эх, ургийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлт хүчин зүйлүүдийг цаг алдалгүй илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эсэн мэнд амаржуулах, төрсний дараах үед тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд чиглэгддэг нэн чухал тусламж үйлчилгээ юм.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь хамтын, тасралтгүй явагдах үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь бодлого боловсруулагчид, мэргэжлийн эмч, эх баригч, сэтгэлзүйч, туслах сувилагч, нөхөн сэргээх эмчилгээний ажилтан, монголын эх барихын нийгэмлэг холбоод, хамт олон, гэр бүл зэрэг өргөн хүрээний багийн хамтын ажиллагаа байдаг. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ учир мэргэшсэн эх баригч болон баг ажиллах шаардлагатай байдаг.

Ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэн гэж эх нялхсын эрүүл мэндийн чиглэлээр үндэсний болон олон улсын стандартад нийцсэн боловсрол мэргэжил эзэмшиж, бэлтгэгдсэн, ур чадвар бүхий мэргэжилтэн хэмээн тодорхойлдог. Ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэн нь төрөх үйл явцад дэмжлэг үзүүлэн, цэвэр, эсэн мэнд амаржих үйл явцыг хангах, эх болон нярайн аливаа хүндрэлийг илрүүлж, удирдаж, шаардлагатай тусламж үзүүлэх чадвартай байх ёстой.

Иймд орчин үеийн, олон улсын бодлого, зарчимд тулгуурласан, эмнэлэгт суурилсан тусламжаас нийгэм- олонд суурилсан тусламж руу, эмч, эмнэлгийн ажилтан төвтэй харилцаанаас эмчлүүлэгч төвтэй харилцаа руу, өвчинд суурилсан тусламжаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд суурилсан тусламж руу чиглэсэн, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий мэргэшсэн эх баригч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах шаардлага тулгарч байна.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Охид эмэгтэйчүүд тэдний гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэнд, нөхөн үржихүйн тусламж үзүүлэхийн тулд эрүүл аюулгүй жирэмслэлтэд бэлтгэх, үнэлэх, шаардлагатай зөвлөгөөг өгөх мэдлэг, эмнэлзүйн цогц чадамжтай, мэргэжлийн ёс зүй, хандлагатай мэргэшсэн эх баригч бэлтгэх.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Жирэмслэлтэд бэлтгэхэд зөвлөгч эх баригчийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эх баригчийн дүр зураг:

ЖИРЭМСЛЭЛТЭД БЭЛТГЭХЭД ЗӨВЛӨГЧ ЭХ БАРИГЧ нь жирэмслэхээс өмнөх үеийн зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн аюулгүй, эрүүл жирэмслэлтэд бэлтгэх, эмэгтэйчүүдийн бие бялдрын болон сэтгэл зүйн сайн сайхны төлөө бэлтгэх, эцэг эх болоход нь бэлтгэх, гарч болох эрсдэлээс сэргийлэхийн тулд нөхөн үржихүйн цогц тусламж үйлчилгээг үзүүлэх **МЭРГЭШСЭН ЭХ БАРИГЧ МЭРГЭЖИЛТЭН** байна. Мөн түүнчлэн мэргэшсэн эх баригч мэргэжилтэн нь тухайн суралцсан мэргэшлийн чиглэлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад тулгуурлан эх барихуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхээс гадна эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахын тулд бусад эх баригч мэргэжилтнүүдэд заан чиглүүлэх, зөвлөн туслах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нийгмийн халамжийн чиглэлээр холбогдох байгууллага болон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цогц чадамжтай байна.

Монгол Улсад мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх, ажил олгогч нарын хэрэгцээг хангахын зэрэгцээ олон улсын чиг хандлагад нийцсэн мэдлэг, чадвар, хандлага бүхий чадамжтай мэргэжилтэн бэлтгэх зорилтын хүрээнд дараах **мэргэшлийн цогц чадамжийг** эзэмшинэ.

- Жирэмслэхээс өмнөх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж
- Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ ба нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж
- Мэргэжлийн хувьд бие даасан байх
- Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дэргэдэх халуун дулаан харилцагч байх

Жирэмслэхээс өмнөх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж

- Өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн бойжилт буюу бэлгийн амьдралын тухай боловсрол олгох чадамж
- Өсвөр насны хүүхдийн эрүүл хооллолт, архи, тамхи болон бусад сэтгэц нөлөөт бодисын хэрэглээний боловсрол олгох чадамж
- Хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх
- Үйлчлэх хүрээний хүн амд гэр бүл төлөвлөлт, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх
- Жирэмслэхээс өмнөх үеийн эрсдэлийг илрүүлж илгээх

Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ ба нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж

- Хүн амын дунд тандалт судалгааг хийх
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулж ард иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх
- Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх

Мэргэжлийн хувьд бие даасан байх

- Бие даасан үйл ажиллагаа явуулах ба бусад эрүүл мэндийн тусламж үзүүлэгчидтэй хамтран ажиллах, шаардлагатай үед нийгмийн үйлчилгээнд оролцох.
- Охид эмэгтэйчүүдийг эрүүл энх байлгах, үндсэн тусламж үзүүлэхийн тулд оновчтой шийдвэр гаргаж чаддаг байх.
- Эмэгтэй хүн жирэмсэлж, төрөх, өөрийгөө арчлах болон хүүхдээ асран өсгөхөд мэдлэг, ур чадвараа зориулахын зэрэгцээ эмэгтэй, түүний хүүхдийн сайн сайхны төлөө үзүүлж буй үйлчилгээндээ хариуцлагатай хандаж, хариуцлагаа хүлээдэг байх.

Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дэргэдэх халуун дулаан харилцагч байх

- Эмэгтэй болон түүний сонгосон дэмжлэг үзүүлэгч хүмүүст цаг ямагт тусламж өгч, харилцан холбоотойгоор хамтран ажиллах
- Хүнлэг энэрэнгүй, тусч, үнэнч шударга байж нэр төр, үзэл бодол, соёл, заншлыг нь хүндэтгэн тэгш үл ялгаварлаж харилцах
- Эмэгтэй, түүний гэр бүлтэй зөв боловсон эелдэг харилцах
- Харилцаанд гадаад болон зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байх

Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн

Хөтөлбөрийн төгсгөлд Эх барихуйн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах үйл ажиллагааг манлайлан, бие даан ажиллах чадвартай, Жирэмслэлтэд бэлтгэхэд зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн эзэмшсэн ёс зүйг эрхэмлэсэн мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэгдэнэ.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

1. Үйлчлүүлэгчийг жирэмслэлтэд бэлтгэхэд үнэлэх, дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх
2. Нийгэм, сэтгэлзүйн эрсдэлтэй эмэгтэйчүүдийг илрүүлж чиглүүлэх зөвлөгөө өгөх
3. Эмэгтэйчүүдэд эмийн нөлөө хэрхэн нөлөөлөх зөвлөх дэмжлэг үзүүлэх
4. Резус хүчин зүйл үүссэн үйлчлүүлэгчийг үнэлэх, дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх
5. Үргүйдэлтэй эмэгтэйчүүдийг илрүүлж зөвлөгөө өгөх
6. Умайн хүзүү болон хөхний хавдрын эрт илрүүлэг хийх дараагийн тусламжид шилжүүлэх

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй сургалтын технологид тулгуурлан суралцагчийн бие даах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

Аргачлал	Суралцагч эх баригчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Зөвлөгөө өгөх ур чадвар	2-3	8 цаг 7 хоногт 5 удаа	ӨЭМТ, ДНЭ, Амаржих газар, ЕБС	Үйлчлүүлэгч, ЕБС-ын сурагч	Эмнэл зүйн сургагч багш, эмч, эх баригч, сувилагч, үйлчлүүлэгч
Жирэмслэхийн өмнөх үзлэг, тусламж зөвлөгөө өгөх	2-3	8 цаг Өдөр бүр	ӨЭМТ, ДНЭ, Тасаг, ЕБС	Үйлчлүүлэгч, ЕБС-ын сурагч	Эмнэл зүйн сургагч багш, эмч, эх баригч, сувилагч, үйлчлүүлэгч
Эрсдэлтэй эмэгтэйчүүдийг илрүүлэх, зөвлөгөө өгөх	2-3	8 цаг 7 хоногт 5 удаа	ӨЭМТ, ДНЭ, Амаржих газрууд	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, эмч, эх баригч, сувилагч, үйлчлүүлэгч
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тусламж үйлчилгээнд оролцох	2-3	Тохиолдол байгаа үед	Амбулаторийн тасагт	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, эмч, эх баригч, сувилагч, үйлчлүүлэгч
Эрт илрүүлгийг хийх, зөвлөгөө өгөх	2-3	Тохиолдол байгаа үед	ӨЭМТ, ДНЭ, Амаржих газрууд	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш, эмч, эх баригч, сувилагч, үйлчлүүлэгч

Танхимын сургалт (Off-the Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч
Лекц, Семинар	12 хүртэл	7 хоногт 2-3 удаа 2 цаг	Хичээлийн өрөө	РРТ Проектор компьютер	Сургагч багш, хамтран суралцагч
Журнал клуб	6 хүртэл	7 хоногт 1 удаа 2 цаг	Хичээлийн өрөө	РРТ Проектор, компьютер, э.ш-ний өгүүлэл	Сургагч багш, хамтран суралцагч
Дуураймал орчин	6 хүртэл	7 хоногт 1 удаа 2 цаг	Дадлагажуулах өрөө	Хамтран суралцагч, манекин	Сургагч багш

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
8:00-9:00	Журнал клуб	Ганцаарчилсан үзлэг, зөвөлгөө	Ганцаарчилсан үзлэг, зөвөлгөө	Ганцаарчилсан үзлэг, зөвөлгөө	Ганцаарчилсан үзлэг, зөвөлгөө
9:00-12:00	Ганцаарчилсан үзлэг, зөвөлгөө	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
12:00-13:00	Лекц	Семинар	Лекц	Семинар	Семинар
14:00-17:00	Симуляци	Хяналтын тойрон үзлэг, зөвлөгөө өгөх	Хяналтын тойрон үзлэг, зөвлөгөө өгөх	Хяналтын тойрон үзлэг, зөвлөгөө өгөх	Журнал клуб

Бие даан суралцах агуулга (Self-Develoment Training)

- Эх барихуйн тухай орчин үеийн ойлголт, түүхэн хөгжил
- ДЭМБ дахь эх баригч болон эх барихын үүрэг оролцоо
- Эх баригчийн ОУ-ын ёс зүйн дүрэм
- Эх баригчийн удирдлага, манлайлал, менежмент
- Эрүүл Аюулгүй Амаржихуйг олон нийтэд түгээх нь

ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Тойролт 1.

Эрүүлийн тухай ойлголт, жирэмслэхийн өмнөх тусламж үйлчилгээ, зөвлөгөө

- Эрүүл гэж ямар байх вэ?
- Өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж
- Эцэг эх болоход бэлтгэх тухай
- Жирэмслэхээс өмнөх үе мөн эцэг эх болохтой холбоотой хууль эрх зүйн ойлголтууд
- Нөхөн үржихүйн насны эмэгтэйд үзүүлэх тусламж
- Зан үйлийн болон нийгмийн эрсдэлт хүчин зүйлүүдийг илрүүлэх
- Хүүхдийн хүйсийн тухай ойлголт
- Үр дүнтэй ярилцлага зохион байгуулах чадвар (Асуулт асуух, Сонсох)
Сэтгэл зүйн өөрчлөлттэй хүмүүстэй харилцах (хүчирхийлэлд өртсөн, мансуурах бодис, донтолт, сэтгэл гутрал)
- Зөвлөгөө өгөх ур чадварт суралцах

Тойролт 2.

Эрсдэлтэй эмэгтэйчүүдийг илрүүлэх, эмийн нөлөө, зөвлөгөө өгөх

- Донтолттой эмэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь/
- Донтолттой эмэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ /орчин, үйлчлүүлэгч, тусламж үзүүлэгч/
- Донтолттой эмэгчийн оношилгооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/

- Эмийн замбараагүй хэрэглээтэй жирэмсэн эмэгтэйд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, нярайд тавих хяналт
- Уналт таталттай эмгэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь/
- Уналт таталттай эмгэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ /орчин, үйлчлүүлэгч, тусламж үзүүлэгч/
- Уналт таталттай эмгэгийн оношилгооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/
- Сахарын эм байнга хэрэглэдэг үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь/
- Сахарын эм байнга хэрэглэдэг эмэгтэйн оношилгооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/
- Таргалалт, таргалалттай эмэгтэйн зөвлөмж
- Эрхтэн тогтолцооны эмгэгтэй эмэгтэйд үзүүлэх тусламж үйлчилгээ / зүрх, бөөрний эмгэг /
- Резус хүчин зүйл гэж юу вэ? Үнэлэх, жирэмслэлт төрөлтийг төлөвлөх
- Уналт таталттай эмэгтэйг жирэмслэлтэд бэлтгэх төлөвлөгөө боловсруулах, тусламж үзүүлэх
- Сахарын эм хэрэглэдэг эмэгтэйг жирэмслэлтэд бэлтгэх төлөвлөгөө боловсруулах, тусламж үзүүлэх
- Таргалалттай эмэгтэйг жирэмслэлтэд бэлтгэх төлөвлөгөө боловсруулах, тусламж үзүүлэх

Тойролт 3.

Бусад эмгэгийн эрт илрүүлэг, зөвлөгөө өгөх

- Сэтгэл гутралын эрт илрүүлэг
- Орчны аюулгүй байдлыг үнэлэх
- Донтолтын эмгэг илрүүлэх сорилууд
- Жирэмслэхийн өмнөх сэтгэл гутралыг эрт илрүүлэх
- Хорт зуршлын илрүүлэг
- Чихрийн шижингийн эрт илрүүлэг
- Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг
- Хөхний хавдрын эрт илрүүлэг
- Үргүйдлийг илрүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн эмчид шилжүүлэх хамтран ажиллах

Тойролт 4.

Яаралтай тусламж, амилуулах суурь тусламжийн зарчмууд

- Жирэмсэн эхэд үзүүлэх яаралтай тусламж
- Нярайн зүрх-уушгины амилуулах тусламж
- Амилуулах суурь тусламж
- Амилуулах лавшруулсан суурь тусламж
- Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшруулсан тусламж

ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР

№	Тойролтын нэр	Тойролтыг хугацаа /7 хоногоор/	Тойролт хийх байгууллага	
1	Тойролт 1. Эрүүлийн тухай жирэмслэхийн тусламж зөвлөгөө	Эрүүлийн ойлголт, өмнөх үйлчилгээ, зөвлөгөө	2 долоо хоног	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагууд
2	Тойролт 2. Эрсдэлтэй эмэгтэйчүүдийг эмийн нөлөө, өгөх	Эрсдэлтэй илрүүлэх, зөвлөгөө	5 долоо хоног	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагууд
3	Тойролт 3. Бусад эмгэгийн эрт илрүүлэг, өгөх	Бусад эмгэгийн зөвлөгөө	3 долоо хоног	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагууд
4	Тойролт 4. Яаралтай тусламж, амилуулах суурь тусламжийн зарчмууд	Яаралтай тусламж, амилуулах суурь тусламжийн зарчмууд	2 долоо хоног	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагууд

ДОЛОО. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

Суралцагч ба хариуцагч

Сургалтын 3 сарын хугацаанд суралцагч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах боломжтой талаар эргэн зөвлөгөө өгөх, суралцагчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (mentor) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид сард 2-3 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэйгээ танилцан эргэн зөвлөгөө авна.

Суралцагч ба эмнэлзүйн сургагч багш

Суралцагчийн тойролт бүрт сургалт удирдах сургагч багшийг оноож хуваарилна:

- Суралцагч бүр нь тухайн тойролт эхлэхээс өмнө сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч нь тойролтын явцад тавьсан зорилтдоо хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай сургагч багштай ярилцана.
- Суралцагч нь тухайн тойролт дуусахад сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace-based Assessment)

Суралцагч эх баригчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээг сургалтын өмнө + сургалтын явцад + сургалтын дараа тус тус үнэлнэ.

360 хэмийн үнэлгээ (Workplace-Assessment):

Суралцагч мэргэжлийн байх (professionalism) болон зохион байгуулагч, манлайлагч (leader) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 3 сарын сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан сургагч багш, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг нийт 3 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Сорилын шалгалт:

Сургалтын агуулгын хүрээнд олон болон нэг сонголттой сорилоор тойролт бүрийн төгсгөлд шалгалт авна.

Бодлого шалгалт:

Эмнэл зүйн тохиолдол дээр суралцагчийг ажиллуулж үнэлнэ.

Портфолио:

Суралцагч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, дадлага, бие даалт, хичээлийн материалыг үр дүн болгож хадгалах.

Үнэлгээний дүнг хянах:

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг хариуцагч болон суралцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхаарна.
- Тест, тохиолдлын үнэлгээний дүнг суралцагчид танилцуулж, хадгална.
- Суралцагч бүрийн Портфолиод үнэлгээ болон сургагч багштай зөвлөлдсөн зүйлсийн агуулгыг бичиж тэмдэглэх, хадгалах хэрэгтэй.
- Үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулж, сургалтыг төгсгөх үед суралцагчид хариуцагчаас эргэн зөвлөгөө өгнө.

Төгсөлтийн шалгалт

Сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд мэргэшлийн үнэмлэх олгоно.

Сургалтыг төгсгөхийг шийдвэрлэх

Тойролт бүрийг дуусах үед хийгдсэн үнэлгээний дүнг нэгтгэж сургалт эрхлэх байгууллага, сургалтын алба, сургагч багш тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг гаргана. Сургалт дуусах үед 360 хэмийн үнэлгээ, Тест, тохиолдлын үнэлгээ, үнэлгээний дүн, портфолиод үнэлгээ, сургалтын ирцийг харгалзан үзэж сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Шийдвэр гаргах шалгуур:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- 3 сарын хугацаанд “тойролт бүрийн лекц, дадлага, зайлшгүй судлах бие даалтын агуулгын 80%-аас доошгүйг үзэж туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 сарын сургалтын эцэст төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх

талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БА ХЯНАЛТ

Сургалтын хяналтын зөвлөл

Сургалтын хяналтын зөвлөл нь Сургалт эрхлэх байгууллагын даргын шууд удирдлага доор ажиллана:

- Сургалтын хяналтын зөвлөл нь сард 1 удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагчтай холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхийг зорьдог байна.

Хөтөлбөрийн хяналт:

- Сургалтын алба нь хөтөлбөрийн хяналтыг хийнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагчийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын албаны мэргэжилтэн хариуцан сургалтын хяналтын зөвлөлд оруулан хэлэлцүүлж өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

Сургалтын танилцуулга (Orientation)

Сургалт эхлэхийн өмнө сургалтын төлөвлөгөө (program) болон хөтөлбөрийн (curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаа, мэргэжлийн үүрэг хариуцлага, халдвар хамгаалал, ёс зүй харилцаа хандлагын талаар суралцагчид ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш, Эх баригч, Бусад ____

Суралцагчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эх баригчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор ($\leq 19\%$)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд ($\geq 80\%$)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг.	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутаг дах бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: **"Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эх баригчид хэрэг болох уу?"**

эмнэлзүйн ярилцлага хийх, эмнэл зүйн үзлэг хийх үед суралцагчийн ярилцлага хийх ур чадвар, бодит үзлэг хийх ур чадвар, эмнэл зүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, зөвлөгөө өгөх, зохион байгуулах

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар.өдөр / /

Суралцагчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Амаржих газар ДНЭ ӨЭМТ

Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: Эр Эм

Өвчтөний зовуурь илрүүлэх, зөвлөгөө өгөх: Донтолтой эмгэгтэй Уналт таталттай эмгэгтэй Сахарын эм байнга хэрэглэдэг Таргалалтын эмгэг Резус хүчин зүйл Сэтгэл гутралтай Хорт зуршлыг илрүүлэх Чихрийн шижингийн эмгэг Умайн хүзүүний хавдар Хөхний хавдар Үргүйдэлтэй Зан үйлийн эрсдэлт хүчин зүйлс Цус алдах Бусад _____

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын тухай үед суралцагчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.				Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл
Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: <input type="checkbox"/>				
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	
Өвчний түүх авах				
Бодит үзлэг				
Оношилгоо, эмчилгээний менежмент				
Харилцааны ур чадвар	-			
Эмнэл зүйн ерөнхий чадвар				

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагчийн гарын үсэг _____

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт

Өвчний түүх авах	Гэр бүл төлөвлөлтөд (ГБТ) бэлтгэх онцлогт хүрэлцэхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. Өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг.
Бодит үзлэг	ГБТ-ийн эрсдэлийг тооцохуйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.
Эмнэл зүйн, менежмент	Өвчтөн үзэж үнэлдэг – ASA ба бусад үнэлгээнүүд. ГБТ-нд бэлтгэхэд зөв төлөвлөгөө гаргадаг. ГБТ-нд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, жирэмслэлтийг зөв удирдан явуулдаг. • Тохирсон эмчилгээг эхлүүлдэг. • Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, саданд ГБТ-ийн талаар тайлбарлаж өгдөг. Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчтай хүндэтгэлтэй ханддаг. Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. Өвчтөний таатай байдал, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвхи зүтгэл гаргадаг. “Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна!”

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ
(DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Он, сар, өдөр / /

Суралцагчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: ____ Нэгж: ____ Газар: Амаржих газар ДНЭ
 ӨЭМТ ЯТТ

Гардан үйлдэл: Сэтгэл зүйн өөрчлөлттэй хүмүүстэй харилцах (хүчирхийлэлд өртсөн, мансуурах бодис, сэтгэл гутрал) Донтолтын эмгэг илрүүлэх (өсвөр нас, насанд хүрэгч) Уналт таталттай эмэгтэйд тусламж үзүүлэх Сахарын эм хэрэглэдэг эмэгтэйд тусламж үзүүлэх Таргалалттай эмэгтэйд тусламж үзүүлэх Хорт зуршлыг илрүүлэх Чихрийн шижингийн эрт илрүүлэг Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг Хяналтын хуудас бөглөх Бусад _____

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо _

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрөл авсан эсэх зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг.				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд бичдэг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

* Сайн тал:

* Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагчийн гарын үсэг: _____

АШИГЛАХ НОМ ЗҮЙ:

Ном сурах бичиг

- Б.Шижирбаатар. Эх барих. 2007. х 79-89
- Б.Жав. Эх барих. 2007. х 41-52
- Т.Эрхэмбаатар бусад. Эх барих. 2015. х 45-71
- Johns Hopkins. Эх барих эмэгтэйчүүд судлалын гарын авлага. 5 дахь хэвлэл. х 11,65.
- Varneys Midwifery. 5 дахь хэвлэл бүлэг 12, х 313-317
- Williams Obstetrics, F.Gary Cunningham other, 2014, 24th edition, page 46-72

Ашиглах вебсайт

- <https://www.youtube.com/watch?v=IKRT-boQTr>
- https://en.wikipedia.org/.../Maternal_physiological_changes_in_...
- www.coursewareobjects.com/.../208-230_CH08_Lowdermilk.q...
- www.slideshare.net/.../maternal-physiology-in-pregnancy
- www.babycenter.com › ... › Prenatal Care & Tests › Prenatal Care
- www.webmd.com/baby/1to3-months
- <https://www.midwiferytoday.com/articles/10ways.asp/>
- www.wecarepregnancycenter.org/